

Хэнтий аймгийн иргэдээс авсан хэрэглэгчийн үнэлгээний тайлан

2011.03.18

Монгол улсын Засгийн газрын 11-р тогтоолоор батлагдсан “Аймаг нийслэлийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ хийх, үр дүнг үнэлэх журам”-ын дагуу Хэнтий аймгийн бүх сум, хот тосгоны ЗДТГ, ЗАА-наас ажлын хэсэг томилогдон үнэлгээний хуудсаар иргэдээс санал асуулга авч ирүүлснийг нэгтгэн боловсруулав. Уг санал асуулгад Хэнтий аймгийн хэмжээнд нийт 2270 иргэн хамрагдсан нь насанд хүрсэн нийт хүн амын 5,6%-ийг эзэлж байна. Санал асуулгыг явуулахдаа хүн амын нас, хүйс, боловсрол, хөдөлмөр эрхлэлтийн байдлыг харгалзан нийгмийн бүлэг бүрийн төлөөллийг жигд хамруулахыг зорьж сум бүрт хүн амын 5-аас доошгүй хувийг санал асуулгад хамруулсан байна.

Иргэдээс авсан санал асуулгын дүнгээс үзэхэд:

1. Хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтийн талаар:
 - Бүрэн хангалттай – 9.1%
 - Хангалттай – 27.2%
 - Төдийлөн хангалттай биш – 29.8%
 - Хангалтгүй -20.2%
 - Мэдэхгүй – 13.9% буюу судалгаанд оролцогчдын 36,3% нь эерэг,
2. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн талаар:
 - Бүрэн хангалттай – 11.2%
 - Хангалттай – 27%
 - Төдийлөн хангалттай биш – 24.4%
 - Хангалтгүй – 21.6%
 - Мэдэхгүй – 16.6% буюу судалгаанд оролцогчдын 38,2% нь эерэг,
3. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн талаар:
 - Бүрэн хангалттай – 10.4%
 - Хангалттай – 29.3%
 - Төдийлөн хангалттай биш – 26.5%
 - Хангалтгүй – 18.9%
 - Мэдэхгүй – 22,2% буюу судалгаанд оролцогчдын 39,7% нь эерэг,
4. Төрийн үйлчилгээний талаар:
 - Бүрэн хангалттай – 12.7%
 - Хангалттай – 31.9%
 - Төдийлөн хангалттай биш – 24.7%
 - Хангалтгүй – 16.5%
 - Мэдэхгүй – 9.9% буюу судалгаанд оролцогчдын 44,6% нь эерэг хандлагатай үнэлгээ өгсөн байна.

Санал асуулгын үр дүнд бүрэн хангалттай, хангалттай, гэсэн үзүүлэлтүүдийг эерэг үнэлгээнд авч хангалтгүй гэсэн үнэлгээг сөрөг хандлагатай гэж тооцсон бөгөөд төдийлөн хангалттай биш, мэдэхгүй гэсэн үзүүлэлтүүдийг хасч тооцсон болно. Энэхүү санал

асуулгад оролцсон 2270 иргэний 39,7% нь төрийн ажил үйлчилгээнд эерэг үнэлгээ, 19,3% хангалтгүй гэсэн үнэлгээ өгсөн байна. Үлдсэн 41 хувь нь өдийлөн хангалттай биш, мэдэхгүй гэсэн дундаж хариултыг өгсөн байна. Санал асуулгын үнэлгээний аргачлалын онолоор эерэг болон сөрөг үнэлгээнд дундаж хариултыг оруулж тооцдоггүй тул хасаж тооцсон болно. Ерөнхийдөө санал асуулгад оролцсон нийт иргэдийн 41 хувь нь санал асуулгын дүнд дундаж хариулт өгсөн нь иргэдийн нийгмийн идэвх сул байгааг харуулж байна.

Харин 2270 иргэний 44,6 хувь өөрийн үйлчилгээг бүрэн хангалттай буюу хангалттай гэж үнэлсэн нь аймгийн төвд “Нэг цонхны үйлчилгээ”-г нэвтрүүлж, 52 төрлийн төрийн үйлчилгээг иргэдэд үзүүлэх замаар идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа нь үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжид нийцсэн, иргэдэд ил тод, нээлттэй ажиллах, шударга төрийн байгууллага байх зарчмаар зохион байгуулж байгаа олон талт ажлууд үр дүнд хүрч байгааг харуулж байна.

Цаашид хууль тогтоомж, Засгийн газрын үйл ажиллагааны өтөлбөрийн хэрэгжилтийг сурталчлах, иргэдэд тайлагнах ажлыг эрчимлэхэд анхаарч ажиллах шаардлагатай байна.

ДАРГА

А.ГАНТ ӨМӨР